

БАТЛАВ:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга



Б.Нарантуяа

БАТЛАВ:

“Санхүүгийн Тооцоолох Групп” ХХК-ны
захирал



Б.Цолмон

Програм хангамж, компьютерийн ажил үйлчилгээний гэрээ

Улаанбаатар хот

№ 37

2017 оны 03 сарын 13-ны өдөр

Нэг. Ерөнхий зүйл

1. Нэг талаас “Эрүүл мэндийн хөгжлийн төв” /цаашид үйлчлүүлэгч гэх/, түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч Д.Гантуяа, нөгөө талаас “Санхүүгийн Тооцоолох Групп” ХХК /цаашид үйлчлэгч гэх/, түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч Г. Наранчимэг нар харилцан тохиролцож доорхи нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.
2. Энэхүү гэрээний зорилго нь НББ-н програм болон програмтай компьютер техник хэрэгслүүдийн засвар үйлчилгээ, мэдээллийн санг удирдан хөтлөх, хадгалах, програм хангамжуудын найдвартай ажиллагааг ханган нэмэлт өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хийх, сүлжээ болон сүлжээний тохиргоо хийх зэрэг ажил үйлчилгээг гүйцэтгэхэд оршино.
3. Гэрээг 2017 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаагаар байгуулав.
4. Програмын гэрээний үнэ 570,240 төгрөг байна.

Хоёр. Талуудын үүрэг, эрх, хариуцлага

➤ Үйлчлэгч тал нь:

1. Гэрээт үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хийж гүйцэтгэнэ.
2. Үйлчилгээний төлбөрийг гэрээ байгуулсан өдрөөс тооцож авах.
3. Үйлчлүүлэгч төлбөрөө хугацаандаа төлөөгүй бол мөрдөж буй ердийн тарифаар тооцож авах
4. Гэрээнд дараах үйлчилгээ хамаарна.
 - ✓ Хууль тогтоомжийн дагуу програмд гарсан өөрчлөлтийг хийх
 - ✓ Програм хангамж ашиглах зөвлөгөө өгөх